

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
БСШУСЯ	Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



ХҮҮХДИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН
ДАРГА Д.ОЮУНБИЛЭГ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.02.20 № 06/549
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүүхдийн төв номын сангийн төсвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хүүхдийн төв номын сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хүүхдийн төв номын сангийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хүүхдийн төв номын сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Хүүхдийн төв номын сангийн дарга Д.Оюунбилэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн цалин хөдөлмөрийн хөлсний тооцоолол тайлагналыг үнэн зөв хийх, тушаал шийдвэрт холбогдох заалтыг бүрэн гүйцэд тусгаж байх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүүхдийн төв номын сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүүхдийн төв номын сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 23-наас 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Мүүрь Аудит ХХК-ийн Н.Дагийрагчаа ахлагчтай аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Хүүхдийн төв номын сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Мүүрь Аудит ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 9 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хүүхдийн төв номын сангийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь хүүхэд, залуучуудад төрөл бүрийн ном, хэвлэл, мэдээллээр үйлчилж ард түмнийг соён гэгээрүүлэх хөтөч нь байх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Засгийн газрын 2004 оны 196 дугаар тогтоолоор хүүхэд залуусыг ном, хэвлэлээр хангах тэдний мэдлэг, хэрэгцээнд зориулсан үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий бие даасан байгууллага болгон өргөжүүлсэн. Хүүхдийн төв номын сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Нийтэд үйлчлэх 6 танхим, хүүхэд залуучуудад үйлчлэх 1 зөөврийн номын сангаар дамжуулан:

- Уншлагын танхимын үйлчилгээ;
- Гэрээр ном олгох үйлчилгээ;
- Зөөврийн номын сангийн үйлчилгээ;
- Цахим номын сангийн үйлчилгээ;
- Соёл, олон нийтийн ажил;
- Лавлагаа, мэдээллийн үйлчилгээ;
- Ерөнхий боловсролын сургуулийн номын санчдад сургалт, арга зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг тус тус үзүүлж байна.

2. Ерөнхий удирдлага, арга зүйн хүрээнд:

- Хүүхдийн төв номын сангийн сан хөмрөгийг шинэчлэх, хадгалалт хамгаалалтыг сайжруулах;
- Хүүхдийн төв номын сангийн үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэх, шинэчлэл хийх;
- Хүүхдийн ном, хэвлэлийн архивын болон мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагаа юм.

Хүүхдийн төв номын сангийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Соёлын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Боловсролын тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль;
- Номын сангийн тухай хууль;
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль;

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын тухай хуулийн шимтгэлийн хувь хэмжээнд болон ХХОАТ-ын тухай хуулийн хөнгөлөлтийн шатлалын хэмжээнд өөрчлөлтүүд орсон бөгөөд оны эхнээс мөрдөгдөж байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль батлагдсантай холбоотойгоор 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд, 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсныг мөрдөж байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллага нь БСШУСЯ-ны сайдын 2017 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/40 тоот тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хүүхдийн төв номын сан нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн "Acolous", Цалингийн "Payroll" болон Номын сангийн "Lib4" зэрэг программ хангамж ашиглаж байна.

Хүүхдийн төв номын сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд *Дунд* гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт *үр нөлөөтэй* байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хүүхдийн төв номын сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 21 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын тайлангийн *Нийт зардлыг* сонгож, эрсдэлийн түвшинг "*дунд*" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн *Нийт зардал 443,794.7* мянган төгрөгөөс 1 хувиар тооцон **4,437.9** мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг сонгосон суурь түвшин болон хувь хэмжээг өөрчлөх шаардлагагүй гэж үзэн 2019 оны Санхүүгийн тайлангийн Үр дүнгийн тайлан дахь нийт зардлын 1 хувиар тооцсон бөгөөд **6,418.2** мянган төгрөг болсон нь жилийн эцсээр Нийт зардлын дүн өссөнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хүүхдийн төв номын сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 35,073.3 мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, Засгийн газрын хувь оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	229.7	52.8	-176.9
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	12,540.0	15,215.3	2,675.2
Үндсэн хөрөнгө	524,857.9	557,432.9	32,575.0
Нийт хөрөнгө	537,627.6	572,700.9	35,073.3
Өр төлбөр	-	111.8	111.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	537,627.6	572,589.2	34,961.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	537,627.6	572,700.9	35,073.3

Авлага дансны үлдэгдэл буурсан нь НДШ-ийн илүү төлөлт буурснаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2019 онд үүссэн НДШ-ийн илүү төлөлтийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь 2019 онд хэрэгжүүлсэн Уншлагыг дэмжих жилийн хүрээнд хийгдсэн хуруун хүүхэлдэй зэрэг жижиг хэрэглэлүүд хийгдсэнтэй холбоотой. Бараа материалын дансны үлдэгдэлд 2019 онд худалдаж авсан ашиглагдаагүй 4,853.3 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 2,105.6 мянган төгрөгийн аж ахуйн материал, 8,256.4 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал байна. Мөн тайлант онд хандиваар 16,619.5 мянган төгрөгийн Д.Нацагдорж нэрэмжит тэргүүний уншигчийн үнэмлэх, тэмдэг, шагналын ном, сэтгүүлийг орлогодон авч уншигчдад бэлэглэсэн.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь номын фондод зузаатгал хийгдсэнээс шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар 26,564.5 мянган төгрөгийн ном, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 15,832.8 мянган төгрөгийн ном хамтран ажиллагч байгууллага болох Тайваны номын сан, Өвөр монголын өөртөө засах орны ном хэвлэлийн хорооны хамт олон, Зохиолч, Хэвлэлийн газруудаас хандивласан ном бүртгэн авч хөрөнгө нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгөөс акталсан 7,392.2 мянган төгрөгийн ном, 11,195 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь завсар аудитын үед цалингийн тооцоололд засвар оруулж ХХОАТ-ын төлөлтийн өр үүссэнээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2019 оны 111.8 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалан 34,961.5 мянган төгрөгөөр өссөн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд Хүүхдийн төв номын сан тайлант оны батлагдсан төсөвт төвлөрүүлэх орлогын дүн тавигдаагүй ба гүйцэтгэлээр 11,814.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж 365.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Уншигчийн үнэмлэх нээлтийн орлого 10,759.2 мянган төгрөг байсан ба уншигчдыг идэвхжүүлж ном уншлагыг дэмждэг хөтөлбөрт арга хэмжээнүүд их зохион байгуулдагтай холбоотой. Гэрээр ном олголтын орлого 812.1 мянган төгрөгөөр давсан нь уншигчдын уншлагыг дэмждэгтэй холбоотой. 243.4 мянган төгрөгийн бусад орлого нь уншигчдад материал

хувилан олшруулах үйлчилгээ үзүүлснээс болон ном захиалгын хуудасны борлуулалтаас бүрдэж байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Соёл урлагийн хөтөлбөрт зориулан 594,356.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 566,356.3 мянган төгрөгийг урсгал зардалд, 28,000.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 594,356.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: 2019 онд Хүүхдийн төв номын сан нь 11,814.6 мянган төгрөгийн өөрийн орлого бүрдүүлснээс Үндсэн хөрөнгөд 2,390.0 мянган төгрөг, Арга хэмжээнд 2,542.7 мянган төгрөг, урамшуулал цалинд 2,605.0 мянган төгрөг, уншигчдад зориулсан арга хэмжээнд 3,551.4 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 360.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж 365.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Дэлхийн зөн олон улсын байгууллагаас Баянхошуу дахь номын санчийн цалин болох 9,618.8 мянган төгрөгийг орлого орж, мөн дүнгээр цалингийн зардалд зарцуулагдсан. Мөн дээд шатны байгууллагуудаас тухайлсан арга хэмжээнүүдэд зориулан 28,244.0 мянган төгрөгийн санхүүжилт орж, Цалингийн зардал 6,356.7 мянган төгрөг, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд 18,560.0 мянган төгрөг, дотоод томилолтод 3,327.3 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 21 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 8 эрсдэл тодорхойлж нийт 29 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 12,394.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 11,816.6 мянган төгрөгийн данс андуурсан гүйлгээ, 527.0 мянган төгрөгийн цалингийн гүйлгээ, 30.0 мянган төгрөгийн дутуу тооцоолсон элэгдлийн зардал зэрэг нийт 12,373.6 мянган төгрөгийн 5 гүйлгээг залруулж, 20.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хүүхдийн төв номын сангийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хүүхдийн төв номын сан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна. Мөн Шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүрд нь ил тод мэдээлж байсан. www.shilendans.gov.mn/org/1152, www.mccl.mn

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Нийт 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа байгаа ба хэрэгжилт 99 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хүүхдийн төв номын сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй алдаа зөрчлийн дүн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшинээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хүүхдийн төв номын сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Цалингийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тэтгэвэрт гарсан ажилтанд олгосон урамшууллаас НДШ-ийн суутгалыг энгийн ажилтантай ижил 24 хувиар суутгал хийсэн боловч НДШ-ийн тайланд тайлагнахдаа тэтгэврийн ажилтнаас суутгах хувь хэмжээгээр суутган тайлагнаснаас НДШ-ийн өглөгийн зөрүү үүссэн.

1.2. Эрсдэл:

НДШ-ийн тайлан алдаатай тайлагнагдах, ажилтанд олгогдож буй урамшуулал дутуу олгогдох эрсдэлтэй.

1.3. Өгсөн зөвлөмж:

НДШ-ийн тайлан гаргахдаа суутгасан хувь хэмжээгээр тайлагнаж зөрүү үүсгэхгүй байх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтан нар танилцаж хүлээн зөвшөөрсөн болно.

2. Тушаал шийдвэртэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Хүүхдийн төв номын сангийн ажиллагсдын орон тоог жил бүр баталж өгдөг ба батлагдсан тоонд ажилчдаа ажиллуулж, шаардлагатай албан тушаалыг ажилчид хавсран ажилдаг. Уг ажилтны хөдөлмөрийн гэрээг хийхдээ хавсран ажиллах ажлын байрны нэрийг 2019 оноос тусгадаг болсон. Өмнөх гэрээнүүд дээр тусгагдаагүй тул олон жил ажиллаж байгаа ажилтанд тухайн үед тушаал гарган ажиллуулж байсан.

2.2. Эрсдэл:

Хавсран ажиллаж байгаа ажлын хөлсний дүн тодорхойгүйгээс цалинг илүү дутуу олгох.

2.3. Өгсөн зөвлөмж:

Ажилтны хөдөлмөрийн гэрээнд хавсран ажиллах ажлын байр мөн нэмэгдэл цалингийн хэмжээ буюу тухайн хавсран гүйцэтгэж буй албан тушаалын цалингийн шатлал, нэмэгдлийн хувийг тодорхой тусгаж байх. Хөдөлмөрийн гэрээнд тусгаадаагүй ажилчдын гэрээг шинэчлэн дээрх мэдээллийг оруулж батлах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтан нар танилцаж хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хүүхдийн төв номын сангийн захирал Д.Оюунбилэг, нягтлан бодогч Э.Батбаатар болон холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,769,759.05	15,268,060.00
31	МӨНГӨ	-	-
33	АВЛАГА	229,734.04	52,800.00
335	Бусад авлага	229,734.04	52,800.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	229,734.04	52,800.00
3351	Байгууллагаас авах авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	12,540,025.01	15,215,260.00
351	Түүхий эд материал	7,536,130.00	8,256,390.00
35110	Тусгай зориулалтын материал	7,536,130.00	8,256,390.00
354	Хангамжийн материал	5,003,895.01	6,958,870.00
35410	Бичиг хэргийн материал	3,465,675.00	4,853,300.00
35420	Аж ахуйн материал	172,020.01	739,370.00
35470	Бусад хангамжийн материал	1,366,200.00	1,366,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	524,857,885.01	557,432,854.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	524,857,885.01	557,432,854.29
392	Биет хөрөнгө	524,857,885.01	557,432,854.29
39203	Авто тээврийн хэрэгсэл-анхны өртөг	21,000,000.00	21,000,000.00
39204	Авто тээврийн хэрэгсэл-хуримтлагдсан элэгдэл	(21,000,000.00)	(21,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж/компьютер/- анхны өртөг	106,082,308.50	104,098,445.50
39206	Машин тоног төхөөрөмж/компьютер/- хуримтлагдсан элэгдэл	(97,896,037.77)	(97,190,318.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил-Анхны өртөг	96,440,596.82	89,619,447.82
39208	Тавилга, аж ахуйн эд хогшил-Хуримтлагдсан элэгдэл	(82,138,474.90)	(76,469,327.05)
39217	Номын фонд	502,369,492.36	537,374,606.12
393	Биет бус хөрөнгө	-	-
39301	Программ хангамж-Анхны өртөг	4,179,100.00	4,179,100.00
39302	Программ хангамж-Хуримтлагдсан элэгдэл	(4,179,100.00)	(4,179,100.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	537,627,644.06	572,700,914.29
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	111,763.74
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	111,763.74
413	Өглөг	-	111,763.74
4131	Ажиллагчидтай холбогдсон өглөг	-	111,763.74
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН	537,627,644.06	572,589,150.55
51	Засгийн газрын хувь оролцоо	537,627,644.06	572,589,150.55
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ Орон нутгийн сан	398,693,113.63	398,693,113.63
51101	Өмч : - Төрийн	398,693,113.63	398,693,113.63
512	Хуримтлагдсан үр дүн	100,993,435.54	135,954,942.03
51210	Өмнөх үеийн үр дүн	73,880,306.53	100,993,435.54
51220	Тайлант үеийн үр дүн	27,113,129.01	34,961,506.49
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	37,941,094.89	37,941,094.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	537,627,644.06	572,700,914.29

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	578,065,442.00	676,776,579.19
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,646,342.00	32,452,295.07
120	Нийтлэг татварын бус орлого	25,646,342.00	32,452,295.07
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	25,646,342.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,409,740.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	626,201.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,610,401.00	32,452,295.07
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	552,419,100.00	644,324,284.12
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	516,582,200.00	594,356,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	516,582,200.00	594,356,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,836,900.00	49,967,984.12
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	8,597,600.00	9,618,750.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,979,000.00	8,430,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,260,300.00	31,919,234.12
134001	Нийгмийн даатгалын сангаас	-	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	527,939,258.33	634,422,891.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	527,939,258.33	634,422,891.70
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	512,226,034.55	626,687,036.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	287,905,635.66	363,213,295.58
210101	Цалин	287,775,635.66	363,213,295.58
210104	Шагнал урамшуулал	130,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,746,912.84	46,287,746.32
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	23,872,617.36	32,634,473.89
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,871,296.31	3,701,661.37
210203	ҮОМШӨ-ний даатгалын шимтгэл	2,241,358.65	2,864,053.70
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	535,469.45	644,321.67
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,226,171.08	6,443,235.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	137,047,200.00	137,047,200.00
210304	Байрны түрээс	137,047,200.00	137,047,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,069,745.58	52,734,091.06
210401	Бичиг хэрэг	7,246,989.00	7,711,539.00
210402	Тээвэр шатахуун	2,328,160.00	2,500,000.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	5,695,661.58	5,622,902.74
210404	Ном, хэвлэлийн зардал	-	1,386,450.31
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	550,000.00	485,500.00
210406	Бага үнэтэй түргэн элдэгдэх зүйл	9,043,036.00	4,486,900.00

210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	30,540,799.01
210408	Бараа материал ақталсны зардал	4,205,899.00	-
2105	Нормативт зардал	-	-
210503	Зөөлөн эд хогшил, нормын хувцас худалдан авах зардал	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	357,994.00	2,398,200.00
210604	Урсгал засвар	357,994.00	2,398,200.00
2107	Томилолт, зочны зардал	2,580,800.00	5,913,281.00
210702	Дотоод томилолт	2,580,800.00	5,913,281.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,752,000.00	14,273,078.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,227,600.00	8,532,098.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох үйлчилгээ	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	95,400.00	114,480.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	95,000.00	93,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	800,000.00	2,000,000.00
210809	Улсын мэдээллийн маягтын зардал	1,501,000.00	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,765,746.47	4,820,144.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,260,300.00	-
210903	Элэгдлийн зардал	3,505,446.47	4,820,144.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,713,223.78	7,735,855.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,624,820.00	7,266,730.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,020,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,604,220.00	7,266,730.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,088,403.78	469,125.26
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,088,403.78	469,125.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	50,126,183.67	42,353,687.49
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	23,013,054.66	7,392,181.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	23,013,054.66	7,392,181.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(23,013,054.66)	(7,392,181.00)
5	НИЙТ ҮР ДҮН	27,113,129.01	34,961,506.49

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	564,787,816.00	644,033,690.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,368,716.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	12,368,716.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	12,368,716.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,742,515.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	626,201.00	-
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	552,419,100.00	644,033,690.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	516,582,200.00	594,356,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	516,582,200.00	594,356,300.00
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,836,900.00	49,677,390.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	8,597,600.00	9,618,750.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчийн	23,979,000.00	8,430,000.00
131105	Төсвийн байгууллагын ажил үйлчилгээний нэмэлт орлого	3,260,300.00	31,628,640.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	521,434,516.00	615,079,190.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	521,434,516.00	615,079,190.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	505,721,292.22	607,343,335.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	288,338,204.00	362,646,050.00
210101	Үндсэн цалин	218,815,151.00	284,005,150.00
210102	Нэмэгдэл	28,339,000.00	38,320,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,320,000.00	40,320,000.00
210104	Урамшуулал	864,053.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,826,062.64	46,275,700.00
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	23,640,672.64	32,170,900.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,809,000.00	3,526,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын шимтгэл	2,196,630.00	2,821,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	561,760.00	705,200.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,618,000.00	7,052,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	137,047,200.00	137,047,200.00
210304	Байрны түрээс	137,047,200.00	137,047,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,150,325.58	19,980,403.05
210401	Бичиг хэргийн материал	7,113,234.00	5,485,350.00
210402	Тээвэр шатахуун	2,291,300.00	2,500,000.00
210403	Шуудан холбоо	5,695,661.58	5,622,902.74
210404	Ном хэвлэл	-	1,386,450.31
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	550,000.00	485,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,500,130.00	4,500,200.00
2105	Нормативт зардал	1,645,100.00	1,645,000.00

210503	Нормын хувцас, Зөөлөн эдлэл	1,645,100.00	1,645,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,022,600.00	2,491,200.00
	Багаж, техник, хэрэгсэл	66,000.00	-
210604	Урсгал засварын зардал	2,956,600.00	2,491,200.00
2107	Томилолт, зочны зардал	2,580,800.00	5,913,281.00
210702	Дотоод томилолт	2,580,800.00	5,913,281.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,850,700.00	31,344,501.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,326,300.00	25,603,521.00
210802	Аудит баталгаажуулалт, зэрэглэл	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	95,400.00	114,480.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	95,000.00	93,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800,000.00	2,000,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлдэх	1,501,000.00	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,260,300.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,260,300.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,713,223.78	7,735,855.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,624,820.00	7,266,730.00
213207	Тэтгэвэрт гарахад нэг удаагийн тэтгэмж	9,020,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,604,220.00	7,266,730.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,088,403.78	469,125.26
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,088,403.78	469,125.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)	43,353,300.00	28,954,499.69
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	43,353,300.00	28,954,499.69
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	43,353,300.00	28,954,499.69
2200	Дотоод эх үүсвэрээр	43,353,300.00	28,954,499.69
225106	Биет олон биет бус хөрөнгө худалдан авсан зардал	43,353,300.00	28,954,499.69
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(43,353,300.00)	(28,954,499.69)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл	398,693,113.63	124,990.50	77,256,040.09	476,074,144.22
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(3,375,733.56)	(3,375,733.56)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		37,816,104.39		37,816,104.39
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		37,816,104.39		37,816,104.39
Тайлант үеийн үр дүн			27,113,129.01	27,113,129.01
2018 оны 12-р сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл	398,693,113.63	37,941,094.89	100,993,435.53	537,627,644.05
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	398,693,113.63	37,941,094.89	100,993,435.53	537,627,644.05
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Тайлант үеийн үр дүн			34,961,506.49	34,961,506.49
2019 оны 12-р сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл	398,693,113.63	37,941,094.89	135,954,942.03	572,589,150.55

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ				
1.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2+5)	594,356,300.00	594,252,782.74	103,517.26	100
2.НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН (3+4)	594,356,300.00	594,252,782.74	103,517.26	100
3.УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	594,356,300.00	594,252,782.74	103,517.26	100
Бараа ажил үйлчилгээний зардал	593,356,300.00	593,342,782.74	13,517.26	100
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	352,620,400.00	352,620,400.00		100
Үндсэн цалин	273,979,500.00	273,979,500.00		100
Нэмэгдэл	38,320,900.00	38,320,900.00		100
Унаа болон бусад нөхөн олговор	40,320,000.00	40,320,000.00		100
Урамшуулал				
Нийгмийн хамгааллын шимтгэл	44,077,600.00	44,077,600.00		100
Тэтгэврийн даатгалын шимтгэл	29,972,800.00	29,972,800.00		100
Тэтгэмжийн даатгал	3,526,200.00	3,526,200.00		100
ҮОМШӨ-ний даатгал	2,821,000.00	2,821,000.00		100
Ажилгүйдлийн даатгал	705,200.00	705,200.00		100
Эрүүл мэндийн даатгал	7,052,400.00	7,052,400.00		100
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	137,047,700.00	137,047,200.00	500.00	100
Байрны түрээс	137,047,700.00	137,047,200.00	500.00	100
Хангамж, бараа материалын зардал	46,185,000.00	46,184,902.74	97.26	100
Бичиг хэргийн материал	4,880,200.00	5,125,350.00	(245,150.00)	105
Тээвэр, шатахууны зардал	2,500,000.00	2,500,000.00		100
Шуудан холбооны зардал	5,819,100.00	5,622,902.74	196,197.26	96.6
Ном хэвлэлийн зардал	28,000,000.00	27,950,950.00	49,050.00	99.8
Хог хаягдал устгах цэвэрлэх	485,500.00	485,500.00		100
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	4,500,200.00	4,500,200.00		100
Нормативт зардал	1,645,100.00	1,645,000.00	100.00	100
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах	1,645,100.00	1,645,000.00	100.00	100
Эд хогшил худалдан авах зардал	2,500,000.00	2,491,200.00	8,800.00	99.6
Урсгал засварын зардал	2,500,000.00	2,491,200.00	8,800.00	99.6
Томилолт, зочны зардал	2,590,000.00	2,586,000.00	4,000.00	99.8
Гадаад албан томилолт				
Дотоод албан томилолт	2,590,000.00	2,586,000.00	4,000.00	99.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	6,690,500.00	6,690,480.00	20.00	100
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	949,500.00	949,500.00		100
Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2,000,000.00	2,000,000.00		100
Даатгалын үйлчилгээ	114,500.00	114,480.00	20.00	100
Тээврийн хэрэгслийн татвар	93,500.00	93,500.00		100
Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00		100
Мэдээлэл технологийн үйлчилгээ	2,000,000.00	2,000,000.00		100
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,500,000.00	1,500,000.00		100
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	910,000.00	90,000.00	91
Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	910,000.00	90,000.00	91
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	1,000,000.00	910,000.00	90,000.00	91
Төвлөрүүлэх шилжүүлэх				

4.ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	594,356,300.00	594,252,782.74		100
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	594,356,300.00	594,252,782.74		100
Улсын төсвөөс санхүүжих	594,356,300.00	594,252,782.74		100
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих				
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих				
Нэмэлт санхүүжилт				
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж				
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө				
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого				
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ОНЫ ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ				
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
Байгууллагын тоо				
Ажиллагсад бүгд	32	32		100
Удирдах ажилтан	1	1		100
Гүйцэтгэх ажилтан	23	23		100
Үйлчлэх ажилтан	8	8		100
Гэрээт ажилтан				

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ		-
1.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		49,311,782.00
2.НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН (3+4)		49,311,782.00
3.УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		49,311,782.00
Бараа ажил үйлчилгээний зардал		42,955,052.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал		10,078,450.00
Үндсэн цалин		10,078,450.00
Нийгмийн хамгааллын шимтгэл		2,145,300.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл		2,145,300.00
Бараа ажил үйлчилгээний урсгал зардал		360,000.00
Бичиг хэргийн материал		360,000.00
Эд хогшил худалдан авах		2,390,000.00
Багаж, техник, хэрэгсэл		90,000.00
Тавилга		2,300,000.00
Томилолт, зочны зардал		3,327,281.00
Дотоод албан томилолт		3,327,281.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс		24,654,021.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж		24,654,021.00
4.УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		6,356,370.00
Бусад урсгал шилжүүлэг		6,356,370.00
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал		6,356,730.00
Төвлөрүүлэх шилжүүлэг		
5.ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		49,311,782.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		49,311,782.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		9,618,750.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		8,430,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		31,263,032.00
Бусад		-
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ОНЫ ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ		-
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт		-
Байгууллагын тоо		
Ажиллагсад бүгд		32
Удирдах ажилтан		1
Гүйцэтгэх ажилтан		23
Үйлчлэх ажилтан		8
Гэрээт ажилтан		

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Хүүхдийн төв номын сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2020.02.06			САГ-2020/147/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<i>Хүүхдийн төв номын сан</i>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
					Албан тушаал	Овог нэр
А	3	4	5	8	9	10
1	Нэгтгэл хийхэд А/33 тушаалын дагуу урамшуулал олгохдоо тэтгэвэрт гарсан ажилтнаас нийгмийн даатгалын шимтгэлийг 24 хувиар буюу 20.68 мянган төгрөгөөр илүү суутгасан.	20.7	Зөвлөмж өгөх	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Э.Батбаатар

